



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/50

Мандалговь

Отрын штабт зардал гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "б", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 03-ний өдрийн 04 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Төв, Говь-Сүмбэр, Хэнтий, Сүхбаатар аймгийн нутагт ажиллах аймгийн отрын штабт зарцуулах түлш, шатахуун, хоол, холбоо мэдээлэл болон үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Отрын штабт зарцуулах 3,448,400 (Гурван сая дөрвөн зуун дөчин найман мянга дөрвөн зуун) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг Даргын Тамгын Газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

Гурав. Дээрх аймгуудад ажиллах отрын штабын үйл ажиллагаанд хяналт тавин хэрэгжилтийг ханган ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэочир)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

48121012!